

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: Хүнсний бүтээгдэхүүн

Техникийн тодорхойлолтын хураангуй. Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Мах, дайвар бүтээгдэхүүн	Мах дайвар бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мал, амьтны мах, малын гэдэс дотор, толгой, шийр орно. /Хуам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй/ Мах нь шинэ, чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, гадаргуу цэвэр, гадны үнэр, амтгүй /шивтэр, бензин гэх мэт, хэвлийн хөндийд дайвар бүтээгдэхүүн болон малын ялгадасгүй байх/ байна.
2	Сүү сүүн бүтээгдэхүүн	Монгол буюу түүнтэй дүйцэхүйц сүү, сүүн бүтээгдэхүүнд шингэн сүү, тараг, ааруул, аарц хамаарна.
3	Гурил, гурилан бүтээгдэхүүн	Импортын бус бүтээгдэхүүн /бялуу кекс хамаарахгүй/
4	Төмс, хүнсний ногоо	Импортын бус бүтээгдэхүүн /дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй. Төмс, хүнсний ногоо нь эх орны хөрсөнд ургасан. Ялзарч муудаагүй шинэ, хадгалалт сайтай байна. Тус тусдаа савлагдсан байна. Чулуу, шорооны хольцгүй байна
5	Өндөг	Монгол буюу түүнтэй дүйцэхүйц өндөг байна.
6	Элсэн чихэр	Орос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн болон түүнтэй дүйцэхүйц байна.
7	Цөцгийн тос	Цөцгийн тос нь Монгол улсад үйлдвэрлэгдсэн болон түүнтэй дүйцэхүйц байна.
8	Будаа	Бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шар буурцгийн гаралтай бүтээгдэхүүн орно. Орос улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц Гадны механик хольцгүй, бяцарч хуваагдаагүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна.
9	Ургамлын тос	Орос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн болон түүнтэй дүйцэхүйц байна.

10	<i>Жимс, жимсгээнэ</i>	<i>Компот, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй</i>
----	------------------------	---

1. Хужирт сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг цахим хэлбэрээр олгох учир үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүр нь пос болон кассын машин сууриллуулсан байх.
2. Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх хүнсний дэлгүүр нь сар бүр 3 саяас доошгүй төгрөгийн бараа эргэлтийн хөрөнгөтэй байх /сүүлийн 3 сарын бараа бүтээгдэхүүн татсан баримт/-ыг хавсаргах.
3. Баталгаат жин хэмжүүртэй байх /мэргэжлийн байгууллагын дүгнэлт бүхий/
4. Хүнсний дэлгүүрийн худалдагч нь худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий мэргэжлийн үнэмлэхтэй байх
5. Олгохоор зөвшөөрсөн 10 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээс Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барааны жагсаалтад орсон хүнсний бүтээгдэхүүнд дотоодын давуу эрх тооцох тул тусад нь жагсаалтаар тооцож ирүүлэх
6. Бараа бүтээгдэхүүний гарал үүслийн бичигтэй байх /гарал үүслийн бичиг байхгүй тохиолдолд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төв лабораторийн бичиг авах/
7. Ажилчдын эрүүл мэндийн шинжилгээний дэвтэртэй байх.
8. Худалдаа үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх
9. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо зэрэг улирлын чанартай үнэ нь хэлбэлздэг бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт хэлбэлзэлийг заавал тусгасан байх.